

БАРУУН БҮСИЙН ЭКОЛОГИЙН ЦЭВЭР ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН, НӨӨЦ, ЧАДАВХИ, АШИГЛААЛ, БҮСЧЛЭЛ

Ж.Норолхоожав*

Хураангуй: 2016 оны байдлаар Монгол улсын ДНБ 23 886 409.5 сая төгрөг, үүнээс хөдөө аж ахуйн салбарын ДНБ 2 913 930.9 сая төгрөг буюу 12.2%-ийг эзэлж байна.² Хөдөө аж ахуйн салбар нь сүү сүүн бүтээгдэхүүн, мах, махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ зэрэг манай орны гол экологийн цэвэр бүтээгдэхүүний чухал салбар юм. Мөн тус салбар нь сүүлийн жилүүдэд /2014-2016 онуудад/ тасралтгүй цэвэр өсөлттэй³ байгаа нь энэ салбарын үйлдвэрлэл, борлуулалт нэмэгдэж буйн илрэл юм. Баруун бүсийн ДНБ 1 496 946.2 сая төгрөг бөгөөд үүний 45.4 хувийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээс бүрдүүлж буй нь (МУ-ын статистикийн эмхэтгэл, 2015) энэ салбар нь бүсийн эдийн засгийн чухал салбар гэдгийг харуулж байна. Энэхүү өгүүлээр баруун бүсийн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүсчлэл, нөөц, чадавхи, ашиглалт сэдвийн хүрээнд бүсийн экологийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох сүү, мах, жимс, жимсгэний үйлдвэрлэлд ашиглах боломжтой түүхий эд, материалын нөөц, нөөцийг үйлдвэрлэлд бодитойгоор ашиглаж байгаа байдлыг бүсийн аймаг тус бүрээр судалж нэгтгэн дүгнэхийг зорьсон.

Түлхүүр үгс Баруун бүс, бүсийн сүү, /мах/ үйлдвэрлэлийн нөөц, бодит үйлдвэрлэл, тэдгээрийн зөрүү /ашиглалт/, жимс, жимсгэний үйлдвэрлэлийн үзүүлэлтүүд

1. Баруун бүсийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нөөц, ашиглалт, бүсчлэл

Баруун бүсийн хээлтэгч малын тоо, (www.1212.mn хээлтэгч малын тоо,

* МУИС-ийн Завхан сургууль, (Email) nyoo_od@yahoo.com

2 <http://1212.mn/statHtml/statHtml.do#> дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргаар, салбараар

3 ХАА-н салбарын ДНБ 2014 онд 13.7%, 2015 онд 10.7%, 2016 онд 4.8 %-ийн цэвэр өсөлттэй байна. <http://1212.mn/statHtml/statHtml.do#>, дотоодын нийт бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аргаар, салбараар

бүс, аймаг, нийслэл, сум, багаар) нэг малын сүүний жилийн дундаж гарц⁴-д үндэслэн үйлдвэрлэх боломжтой сүүний хэмжээг тооцсон дүн (Хавсралт 1-ээс харах) дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Баруун бүсийн хэмжээнд үйлдвэрлэх боломжтой сүү, бүсийн хүн амын хэрэгцээт сүү, тэдгээрийн зөрүү /мян.л/,

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
Бүсийн хэмжээнд жилд саах боломжит сүү	23090.4	25660.8	29397.6	32788.8	37994.4
Үүнээс: Гүү	129122.4	145926	170320.7	187124.3	208276.2
Үнээ	3781.6	4026.1	4335.8	4596.6	5084.0
Ингэ	26839.5	29890.5	34431	36813	44364.8
эм хонь	48924	53344.8	60050.4	64848	75822.5
эм ямаа	231757.9	258848.2	298535.5	326170.7	371541.9
Бүсийн хүн ам ¹ -ын хэрэгцээт сүү, мян.л	42767.9	43041.1	44655.7	45706.7	46361.7
Сүү үйлдвэрлэлийн нөөц, хэрэглээний зөрүү	188990.0	215807.1	253879.8	280464.0	325180.2

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Жич: Хүн амын тоог жишмэл хүнд шилжүүлэх коэффициент⁵, жишмэл нэг хүний жилийн хэрэгцээ⁶, кг сүүг литрт шилжүүлэх коэффициент⁷ зэрэгт үндэслэн тооцов.

Сүүлийн жилүүдэд бүсийн хэмжээнд малын тоо толгой төрөл тус бүр дээрээ өссөнтэй холбоотойгоор үйлдвэрлэх боломжит сүүний хэмжээ нэмэгдсээр байна.


4 Баруун бүсэд нэг үнээнээс жилд дунджаар 737, гүүнээс 216, ингэ 163, эм хониноос 15, эм ямаанаас 24 литр сүү саадаг. ХАА-н 2011 оны улсын анхдугаар тооллого, УБ 2011, 210, 212-р тал

5 хүн амын тоог жишмэл хүнд шилжүүлэх коэффициент 0.9 М.Эрдэнэчимэг "Баруун бүсийн мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга зам" докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, УБ 2011, 47-р тал

6 Жишмэл нэг хүний жилийн хэрэгцээ сүү 54.8 кг, сүүн бүтээгдэхүүн 73.0 кг Эх сурвалж: Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, УБ 2015

7 1л сүү =1.03 кг Хөдөө аж ахуйн тооллогын асуулгыг нөхөх заавар УБ 2012

Зураг 1. Баруун бүсийн хэмжээнд үйлдвэрлэх боломжтой сүү /мян.л/, малын төрлөөр



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Гэвч саалинд хамруулж буй малын тоо, нэг эм малаас сааж буй сүү зэргээс хамааран бодит үйлдвэрлэлийн хэмжээ, боломжит хэмжээнээс харьцангуй бага байгаа бөгөөд эдгээрт үндэслэн үйлдвэрлэсэн сүүний хэмжээг тооцож үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Баруун бүсийн сүү үйлдвэрлэл, мян.л, малын төрлөөр

малын төрөл	саалинд хамрагдах хувь	нэг малын сүүний гарц, л, жилд	үйлдвэрлэсэн сүү, мян.л				
			2012	2013	2014	2015	2016
Гүү	65.20%	216	15054.9	16730.8	19167.2	21378.3	24772.3
Үнээ	90.50%	570	90376.9	102138.3	119212.9	130974.3	145779.2
Ингэ	77.30%	163	2923.2	3112.2	3351.6	3553.2	3906.0
эм хонь	59.50%	15	15969.5	17784.8	20486.4	21903.7	24747.2
эм ямаа	72.0%	24.0	35225.3	38408.3	43236.3	46690.6	52408.5
Нийт			159549.8	178174.4	205454.5	224500.1	251613.3


Эх сурвалж. Судлаачийн тооцоолол

Баруун бүс нь үйлдвэрлэх боломжтой сүүнийхээ 68 орчим хувийг бодитойгоор үйлдвэрлэж байгаа ба үнээнээс бусад малын саалинд хамруулалт

хангалтгүй байгаа нь үүний гол шалтгаан юм.

Сүүний үйлдвэрлэлээр баруун бүс нь хангайн болон төвийн бүсийн дараа орж байна.

Зураг 2. Сүү үйлдвэрлэлийн бүсчилсэн зураглал, аймгуудаар



Эх сурвалж: МҮСХ, ХАА-н улсын анхдугаар тооллогын нэгдсэн дүн, 2012

Сүү үйлдвэрлэлийн хэмжээгээр аймгуудыг 5 түвшинд авч үзэж байгаа бөгөөд баруун аймгуудаас Баян-Өлгий, Увс, Завхан дунд, Ховд, Говь-Алтай багавтар түвшинд хамаарч байна.

2. Баруун бүсийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нооц, ашиглалт, бүсчлэл

Монгол улсын хэмжээнд 2012 онд нийт 40.9 сая толгой (МУ-ын статистикийн эмхэтгэл, 2015) мал тоологдож байсан бол 2016 онд 61.5 сая (www.1212.mn) болж өсжээ.

Улсын нийт малын 24.6% нь баруун бүсэд хамаарч байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд малын төрөл тус бүрээр байнгын өсөлттэй байна. Улсын хэмжээнд малаараа тэргүүлж буй аймгуудад баруун бүсээс Говь-Алтай тэмээгээрээ 4-т, ямаагаараа 3-т (МУ-ын статистикийн эмхэтгэл, 2015) багтаж байна.

*, ** - Монгол улсын статистикийн эмхэтгэлд тусгаснаар

Баруун бүсийн малын тоо, толгой (Хавсралт 2-оос харах)-н өсөлтийг сүүлийн жилүүдээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3. Малын тоо, толгойн өсөлт, хувиар

Малын төрөл	Малын өсөлт, хувиар*			
	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016
Адуу	12.2%	15.4%	11.7%	13.6%
Үхэр	17.4%	20.5%	12.7%	9.8%
Тэмээ	4.7%	8.2%	5%	8.7%
Хонь	12.8%	16.9%	8.3%	11.4%
Ямаа	11.0%	14.6%	9.7%	9.3%
Нийт мал	12.0%	15.8%	9.3%	10.3%

*-Монгол улсын статистикийн эмхэтгэл 2015, (www.1212.mn) тусгасан малын тоог үндэслэн тооцов.

Баруун бүсийн махны нөөцийн хэмжээг 2008 оноор тооцож байсан аргачлалын үр дүн⁸-тэй ижил аргачлалаар тооцоход дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Баруун бүсийн хэмжээнд үйлдвэрлэх

боломжтой мах, дотоод хэрэгцээ, зөрүү, тн

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	
Үйлдвэрлэх мах нядалгааны жингээр, тн	Тэмээ	212.6	222.6	240.9	252.9	275.0
	Адуу	3401.8	3817.1	4405.6	4921.3	5590.8
	Үхэр	11450.2	13444.6	16195.7	18252.2	20052.1
	Хонь	20836.8	23495.5	27465.5	29739.9	33142.9
	Ямаа	13063.7	14501.3	16613.4	18229.1	19922.3
Нийт	48965.1	55481.1	64921.0	71395.5	78983.0	
Баруун бүсийн махны хэрэгцээ, жишсэн хүнээр, тн	28769.0	29,241	29,428	30,532	31,250	
Мах үйлдвэрлэлийн боломж, хэрэглээний зөрүү, тн	13997.7	19724.1	26053.4	34389.3	40145.2	

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

8 2008 оны байдлаар баруун бүсийн үйлдвэрлэх мах 60424 тн, махны дотоод хэрэгцээ 33200 тн Эх сурвалж: М.Эрдэнэчимэг "Баруун бүсийн мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга зам" докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, УБ,2011, 59-р тал

Бүсийн хэмжээнд 2011 оны байдлаар улсын хэмжээний мах үйлдвэрлэлийн 16,9% буюу 34223,3 тонн мах үйлдвэрлэсэн⁹ гэсэн тооцоо байгаа бөгөөд энэ нь дээр тооцсон үйлдвэрлэх боломжтой махны 80%-ийг үйлдвэрлэсэн гэсэн үг юм. Үүнтэй адил хувиар жил бүр үйлдвэрлэсэн гэж үзвэл бүсийн мах үйлдвэрлэл дараах байдалтай байна.

Хүснэгт 5. Махны бодит үйлдвэрлэл, хэрэглээний зөрүү, тн

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016
мах үйлдвэрлэл	39172.1	44384.9	51936.8	57116.4	63186.4
Хэрэглээ	29241.0	29427.8	30531.7	31250.3	31698.1
хангамжийн хувь	134.0%	150.8%	170.1%	182.8%	199.3%

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 6. Баруун бүсийн махны үйлдвэрүүд, тэдгээрийн хүчин чадлын судалгаа /2015 оны байдлаар/

№	Аймаг	Үйлдвэрийн нэр	Бүтээгдэхүүний нэр төрөл	Жилийн хүчин чадал, тн			Зориулалтын зоорь агуулах, хүчин чадал, тн
				Бүгд	бод	бог	
1	Баян-Өлгий	“Мах маркет” ХХК	Мах, махан бүтээгдэхүүн	740	140	600	(М.Эрдэнэчимэг, Баруун бүсийн мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга зам, 2011)+
2	Завхан аймаг, Улиастай сум	“Завхан хунс трейд” ХХК	Мах, махан бүтээгдэхүүн	1120	120	1000	+
3	Завхан аймаг, Тэс сум, Арц суурь	“Тэс шим” хоршоо	Мах, махан бүтээгдэхүүн	100	100	0	+
4	Завхан аймаг, Тосонцэнгэл сум	“Мах маркет” ХХК	Мах, махан бүтээгдэхүүн	100	100	0	+

⁹ Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анхдугаар тооллого, УБ,2012, 74-р тал

5	Ховд	“Баруун монгол интернейшль” ХХК	Үхэр, хонь, адууны махан консервь, будаагай хуурга	1100	100	1000	150.0
6		“Хан жаргалант ховд” ХХК	Бүх төрлийн хиам, гахайн мах, зайдас	80	80	0	+
7	Увс	“Мах маркет Увс” ХХК	Мах, махан бүтээгдэхүүн	330	80	250	+


Эх сурвалж: Аймгуудын ХААГазруудын мэдээлэл

Баруун бүсийн мах боловсруулах үйлдвэрүүд нь нэг ээлжиндээ 720 бод, 2850 бог нядлах хүчин чадалтай, хөлдөөлтийн хүчин чадал 143 тн/хоног, хадгалах агуулахын хүчин чадал 4047 тн/хоног байна.

Бүсийн мах үйлдвэрлэлийн сүүлийн 10 жилийн тоон үзүүлэлтээс харахад үйлдвэрүүд хүчин чадлынхаа 1.5-2% хувийг ашиглаж, дунджаар улсын махны экспортын 7-13.3 хувийг хангаж байна. (М.Эрдэнэчимэг, Завхан аймгийн махны хэрэгцээнд тулгуурлан махны кластерийг идэвхижүүлэх боломж, 2015)

Мах үйлдвэрлэлийн хэмжээгээр аймгуудыг 5 түвшинд авч үзэж байгаа бөгөөд баруун аймгуудаас Баян-Өлгий, Увс, Завхан, Ховд дунд, Говь-Алтай бага түвшинд хамаарч байна

Зураг 3. Мах үйлдвэрлэлийн бүсчлэл, аймгуудаар



Эх сурвалж: МҮСХ, ХАА-н улсын анхдугаар тооллогын нэгдсэн дүн, 2012

3. Баруун бүсийн жимс, жимсгэний үйлдвэрлэлийн нөөц, ашиглалт, бүсчлэл

Баруун бүсийн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний нэг төрөл бол жимс, жимсгэнэ юм. Бүсийн аймгуудаас Ховд аймаг шийгуа тариалалтаараа, Увс аймаг зэрлэг болон таримал чацарганаараа, Завхан аймгийн зарим сумууд байгалийн зэрлэг нэрсээрээ алдартай билээ. Эдгээр жимс, жимсгэний тариалалт, ургацын талаар авч үзвэл:

Увсын чацаргана: Дэлхийн зэрлэг чацарганы 60 орчим хувь нь Монголд байдаг. Монгол улсад 29150 га талбайд зэрлэг чацаргана ургадаг гэсэн судалгаа ч бий. Түүнээс 12378 га нь Увс аймгийн нутагт ургадаг. Зэрлэг чацарганы тосны дэлхийн төв нь их нууруудын хотгорт буюу Бөхмөрөний голоос Тэсийн голын хөндий хүртэлх газарт байдаг гэдгийг дэлхийн чацаргана судлаач эрдэмтэд нэгэнт тогтоожээ. Увс аймаг 2005 оны статистик мэдээгээр чацаргана хураалт 13 тн болтлоо буураад байсан үед нь аймгийн “Чацаргана” хөтөлбөр батлагдаж, уг хөтөлбөр өргөн олны дэмжлэг талархал хүлээснээр сүүлийн жилүүдэд тус аймагт 400 гаруй га талбайд чацаргана тариалаад байна. Ийнхүү чацаргана хөтөлбөр Засгийн газрын хөтөлбөр болж улс орны хэмжээний томоохон бүтээн байгуулалт, байгаль орчны шинэ хувьсгал болсон гэхэд болно. (Н.Баасанхүү, “Ургадаг алт” нийтлэл, 2015)

Увс аймгийн чацаргана тариалалт, ургацыг 2012-2016 оны байдлаар авч үзвэл:

Хүснэгт 7. Чацарганы тариалалтын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	хэмжих нэгж	Онууд				
		2012	2013	2014	2015	2016
Тариалсан талбай	га	556.2	564.1	640.0	647.3	565.0
Хураасан ургац	тн	620.7	629.5	715.4	720.4	630.6

Эх үүсвэр: Увс аймгийн ХХААГ газрын мэдээлэл

Ховдын шийгуа, амтаг гуа:

Хүснэгт 8. Ховдын шийгуа, амтат гуа тариалалтын үзүүлэлтүүд

Жимс	Үзүүлэлт	хэмжих нэгж	Онууд				
			2012	2013	2014	2015	2016
Шийгуа	Тариалсан талбай	га	222.5	144.3	150.4	160.4	197.4
	Хураасан ургац	тн	1963.9	2000.0	2170.0	2600.0	2736.4
Амтат гуа	Тариалсан талбай	га	40.0	40.8	40.0	45.0	52.9
	Хураасан ургац	тн	420.0	467.2	450.9	643.2	747.2
Нийт	Тариалсан талбай	га	262.5	185.1	190.4	205.4	250.3
	Хураасан ургац	тн	2383.9	2467.2	2620.9	3243.2	3483.6

Эх сурвалж: Ховд аймгийн ХХААГазрын мэдээлэл

Завханы нэрс:

Нэрс жимс нь Булган, Хөвсгөл, Архангай, Завхан, Хэнтий аймгуудын нутгаар тархалт ихтэй. Байгал орчин ногоон хөгжлийн яамны сайдын “Судалгаа шинжилгээ болон эмийн, хүнсний үйлдвэрлэл, ахуйн зориулалтаар түүж бэлтгэх элбэг ургамлын дээд хэмжээ”-г заасан тушаалд дээрх аймгуудаас нийт 210 орчим тн нэрс түүх боломжтойг тодорхойлсон байдаг. Үүнээс Завхан 95 тн, Хөвсгөл 110 тн нэрс түүх боломжтойгоороо хамгийн их нөөцтэйд багтаж байна.

Дүгнэлт

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд:

- 2012-2016 оны мэдээллүүдэд үндэслэсэн тооцооноос харахад бүсийн хүн амын хэрэгцээнээс үйлдвэрлэл нь эрс их буюу хэрэгцээг бүрэн хангаж, бусад зах зээлд нийлүүлж байгаа мэт дүр зураг харагдаж байна. Гэсэн ч манай орны хувьд хот, хөдөөгийн нэг хүнд ногдож байгаа сүү, сүүн бүтээгдэхүүний ялгаа, импортоор оруулж ирж буй сүүний хэмжээнээс харахад хангамж жигд бус буюу бүсийн үйлдвэрлэгчдээс хот суурин газрын хэрэглээнд сүү, сүүн бүтээгдэхүүнээ нийлүүлж буй байдал сул гэж дүгнэж болохоор байна.
- Үйлдвэрлэлийн боломжит нөөцийн тооцооноос харахад одоогийн үйлдвэрлэлээ улам бүр нэмэгдүүлэх боломж байна.
- Хот суурин газрын зах зээл дэхь нийлүүлэлтийг нэмэгдүүлэх мөн бодит үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд нэгд, саалийн хугацаа урттай фермерийн аж ахуйг хөгжүүлэх, хоёрт, одоогийн үйлдвэрлэлийн нөхцөл байдлаа сайжруулах буюу сүүг цуглуулах, хөргөөх, боловсруулах тогтолцоог хөгжүүлж саалийн хугацаанд хуурай сүү, цөцгийн тос, бяслаг, ааруул зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх уламжлалт болон европ технологи хосолсон жижиг үйлдвэр, цехүүдийг бий болгох

гэсэн боломжит хувилбарууд байна. Бүсийн хувьд аль хувилбар илүү тохиромжтойг судлах шаардлагатай.

Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд:

Мах үйлдвэрлэлийн хувьд бүсийн хүн амын хэрэгцээнээс 90 гаран хувиар давсан (2012-2016 оны дунджаар) үйлдвэрлэл явуулж буй тооцоо гарч байгаа ч бүс, орон нутгийн махны зах зээлээс үйлдвэрлэгчид төдийлөн их орлого олохгүй байгаа билээ. Иймд махны зах зээлийг тэлэх, бусад аймаг, бүс, үндэсний болон экспортын зах зээл рүү борлуулалтаа нэмэгдүүлэх шаардлагатай. Үүний тулд үйлдвэрлэлийн аргаар бэлтгэж буй махны хэмжээг нэмэгдүүлэх, махны кластерийг хөгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Жимс, жимсгэний үйлдвэрлэлийн хувьд:

Увсын чацаргана, Ховдын шийгуаны тариалалт, ургацын хэмжээ жил бүр нэмэгдэж байгаа харин Завханы нэрсний хувьд байгаль дээрх зэрлэг жимсийг хүмүүс түүж борлуулж, зарим үйлдвэрт варень, жимний шүүс үйлдвэрлэж байгаа бөгөөд эдгээр нь аймаг орон нутгийн эдийн засаг, хүн амын ажил эрхлэлт, амьжиргаанд нөлөө үзүүлэхүйц хэмжээнд хүрсэн гэж үзэж байна. Гэсэн хэдий ч энэ талын тооцоо судалгаа, мэдээлэл маш хомс байна. Иймд орон нутгийн хэмжээнд чацаргана, шийгуа тариалагчид, тэдгээрийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажиллах хүч, эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл зэргийг тодруулан судлах шаардлагатай.

Ашигласан материал

1. МУИС-Завхан Сургууль “ОХУ, Монгол улсын зах хязгаар бүс нутгуудын МАА-н гаралтай цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн кластерийг бий болгон хөгжүүлэх нь” судалгааны тайлан, 2016
2. МУҮСХ, ХАА-н улсын 2011 оны улсын анхдугаар тооллого, нэгдсэн дун, УБ, 2012
3. Д.Алтанхуяг “МАА-н гаралтай зарим бүтээгдэхүүний нөөцийн үнэлгээ” ЭШ-ний илтгэл, 2015
4. М.Эрдэнэчимэг “Баруун бүсийн мах махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх арга зам” докторын зэрэг горилсон бүтээл, 2011
5. М.Эрдэнэчимэг “Завхан аймгийн махны хэрэгцээнд тулгуурлан махны кластерийг идэвхижүүлэх боломж” ЭШ-ний илтгэл, 2015
6. ХХААЯ, “Газар хөдлөлтийн гамшгийн үеийн орон нутгийн хүн амын амын хүнсний нөөц тооцох аргачлал” УБ, 2015
7. МУҮСХ, Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, УБ 2015
8. МУҮСХ, Хөдөө аж ахуйн тооллогын асуулгыг нөхөх заавар, УБ, 2012
www.1212.mn

Хавсралт-1 Баруун бүсийн хэээлтэгч малын тоо,
 үйлдвэрлэх боломжит сүү /мян.л/, малын төрлөөр

гүү					
он	2012	2013	2014	2015	2016
Баян-Өлгий	15.6	17.4	20.6	22.8	25.5
Говь-Алтай	15.6	18.8	22.0	25.8	31.6
Завхан	33.3	36.9	41.1	45.2	52.2
Увс	20.1	21.4	24.6	27.4	30.8
Ховд	22.3	24.3	27.8	30.6	35.8
Нийт	106.9	118.8	136.1	151.8	175.9
сүүний жилийн дундаж гарц/1 гүүнээс	216.0	216.0	216.0	216.0	216.0
Жилийн нийт сүүний гарц/ мян.литрээр	23090.4	25660.8	29397.6	32788.8	37994.4
үнээ					
Баян-Өлгий	38.1	43.8	51	55.9	60.2
Говь-Алтай	12.0	15.6	18.8	22.3	26.7
Завхан	38.2	43.5	51.0	57.2	63.2
Увс	46.0	50.3	58.4	62.1	66.6
Ховд	40.9	44.8	51.9	56.4	65.9
Нийт	175.2	198.0	231.1	253.9	282.6
сүүний жилийн дундаж гарц/1 үнээнээс	737.0	737.0	737.0	737.0	737.0
Жилийн нийт сүүний гарц/ мян.литрээр	129122.4	145926	170320.7	187124.3	208276.2
ингэ					
Баян-Өлгий	1.3	1.3	1.5	1.4	1.5
Говь-Алтай	9.0	9.9	10.4	11.4	12.7
Завхан	1.6	1.7	1.8	1.9	1.9
Увс	5.6	5.9	6.3	6.7	7.4
Ховд	5.7	5.9	6.6	6.8	7.5
Нийт	23.2	24.7	26.6	28.2	31

сүүний жилийн дундаж гарц/1 ингэнээс	163	163	163	163	164
Жилийн нийт сүүний гарц/ мян.литрээр	3781.6	4026.1	4335.8	4596.6	5084
эм хонь					
Баян-Өлгий	260	293	346.6	364.5	409.2
Говь-Алтай	246	288.5	335.7	382.4	461.3
Завхан	500.3	556.4	624.3	655.9	725.9
Увс	449.1	487.1	561.6	589.8	639.2
Ховд	333.9	367.7	427.2	461.6	537.2
Нийт	1789.3	1992.7	2295.4	2454.2	2772.8
сүүний жилийн дундаж гарц/1 эм хониноос	15	15	15	15	16
Жилийн нийт сүүний гарц/ мян.литрээр	26839.5	29890.5	34431	36813	44364.8
эм ямаа					
Баян-Өлгий	311.6	331.6	374.3	391.2	417.7
Говь-Алтай	502.1	583.2	660.0	742.1	879.5
Завхан	382.6	420.0	464.4	499	536.5
Увс	376.7	391.6	439.3	463.9	508.2
Ховд	465.5	496.3	564.1	605.8	691.0
Нийт	2038.5	2222.7	2502.1	2702	3032.9
сүүний жилийн дундаж гарц/1 эм ямаанаас	24	24	24	24	25
Жилийн нийт сүүний гарц/ мян.литрээр	48924	53344.8	60050.4	64848	75822.5
Үйлдвэрлэх боломжит нийт сүүний хэмжээ/ мян.л	231757.9	258848.2	298535.5	326170.7	371541.9

Хавсралт-2. Баруун бүсийн малын тоо, мян.тол
/малын төрлөөр, аймгуудаар/

Аймаг	адуу				
	2012	2013	2014	2015	2016
Баян-Өлгий	51.7	58.4	69.6	77.3	85.8
Говь-Алтай	55.0	65.3	76.7	88.4	106.8
Завхан	116.8	130.1	147.4	163.1	186.2
Увс	70.4	76.9	88.4	98.0	105.6
Ховд	75.5	83.8	96.3	107.6	122.7
Нийт	369.4	414.5	478.4	534.4	607.1
Аймаг	үхэр				
	2012	2013	2014	2015	2016
Баян-Өлгий	87.2	105.1	127.4	144.8	155.6
Говь-Алтай	29.5	39.4	49.4	58.8	71.0
Завхан	98.3	115.3	138.9	158.9	172.3
Увс	108.0	122.6	145.4	156.8	161.0
Ховд	100.7	115.1	138.2	156.1	182.1
нийт	423.7	497.5	599.3	675.4	742.0
Аймаг	тэмээ				
	2012	2013	2014	2015	2016
Баян-Өлгий	4.2	4.3	4.7	4.7	4.9
Говь-Алтай	28.2	30.4	32.8	34.7	38.5
Завхан	6.4	6.3	6.6	6.7	6.9
Увс	16.9	17.9	19.5	20.5	21.9
Ховд	18.6	18.9	20.6	21.8	23.9
нийт	74.3	77.8	84.2	88.4	96.1
Аймаг	хонь				
	2012	2013	2014	2015	2016
Баян-Өлгий	574.4	662.8	799.9	850.6	937.7
Говь-Алтай	578.1	679.1	798.2	909.3	1107.1
Завхан	1147.9	1280.0	1464.4	1562.7	1730.2
Увс	976.0	1081.3	1260.5	1337.0	1376.4
Ховд	758.2	846.2	995.1	1098.9	1266.0
нийт	4034.6	4549.4	5318.1	5758.5	6417.4
Аймаг	ямаа				
	2012	2013	2014	2015	2016

Баян-Өлгий	693.1	773.4	882.1	943.7	983.3
Говь-Алтай	1220.3	1409.1	1621.0	1831.3	2173.9
Завхан	910.7	1007.3	1138.6	1241.7	1310.5
Увс	859.3	926.4	1047.4	1116.7	1119.0
Ховд	1085.4	1177.4	1375.5	1521.0	1685.8
нийт	4768.8	5293.6	6064.6	6654.4	7272.5
Нийт мал	9670.8	10832.8	12544.6	13711.1	15135.1